

ОРШИЛ

Японд гадаад хүмүүс ирэх нь жилээс жилд нь нэмэгдэж байгаа нь сүүлийн үеийн мэдээнээс үзэхэд тодорхой, түүнчлэн Японд урт хугацаагаар оршин сууж, амьдарч Японы албан ёсны боловсрол сургалтанд хамрагдах нь их болж байна. Сургуульд хоёроос илүү жил сурахаар, өдөр тутмын яриаг сайн ойлгож, саадгүй ярьдаг болдог хүүхдүүд байдаг ч ерөнхий эрдмийнхээ хичээлийг хийхэд япон хэлнийх нь чадвар хүрэлцэхгүйгээс болоод нэг хэсэгтээ япон хэлний чадвар нь дээшлэхгүй тул дэвшин суралцаж чадахгүй, чадсан ч ахлах болон их сургуулийн хичээлийг гүйцэхгүй байх явдал цөөнгүй байдаг. Боловсролын яамны судалгаагаар хоёроос доош төдийгүй дээш жил суралцсан сурагчдад ч гэсэн япон хэлийг заах хэрэгтэй гэжээ. Өөрөөр хэлбэл, төрөлх хэлээ хэрэглэхийн зэрэгцээ япон хэлийг хоёрдахь хэлээ болгохын тулд япон хэлнийхээ төвшинг дээшлүүлэхэд нь сургалт хэрэгтэй гэсэн үг юм.

Тэгвэл одоогийн байдлаар бол тухайн тухайн үе шатанд нь таарсан сургалтын материал, хэрэгсэл дутуу дулимаг, ялангуяа сургуулийн амьдрал дээр япон хэлнийх нь чадварыг сайжруулах зорилготой сурах бичиг гарахгүй хоцрогдож байна гэж хэлж болно. Ерөнхий эрдмийн хичээлийн үг хэллэгийг хоёрдугаар хэл болох япон хэлээрээ шууд ойлгох чадвар хэрэгтэй. Тийм учраас бусад хичээлийн үг хэллэгийг оруулсан үр дүн сайтай сургалтын материал байвал, өөрөө суралцаж, хичээлээс гадуурх япон хэл заадаг сайн дурын байгууллагыг ашиглавал япон хэлнийх нь чадвар дээшилж, Японд япон хэлээр сэтгэл хангалуун амьдрахад нь тус нэмэр болно гэж бодож байна.

Иймээс NPO (ашгийн бус, хууль эрхт байгууллага), дунд, ахлах дунд сургуулийн япон хэл сургалтыг дэмжих нийгэмлэг голлон, хичээлд хэрэглэгдэх үгсийн санг тусгайлан гаргаж "ерөнхий эрдмийн хичээлд хэрэглэх үгсийн сан" гэдэг цуврал хэвлүүллээ. Одоогоор португал, испани (5,000 үг), хятад (6,000 үг) хэлнийх бэлэн болоод байна. Энэ бол тэдгээрийн монгол хэлний цуврал нь юм. Япон Монголын соёл нэлээд ялгаатайг бодолцон бага сага үг, өгүүлбэр нэмж оруулан эмхэтгэв.(6,018 үг, 7,293 жишээ өгүүлбэр). Бие даан суралцах заншилтай болгох талаар анхаарав. Жишээлбэл ("Энэ номын хэрэглэх арга"- гаас тодорхой үзэж болно) бүх толгой үгэнд хичээлд олон удаа гарч ирдэг өгүүлбэрийн жишээг нэмж оруулсан бөгөөд, бүх канжны дуудлагыг хираганаар бичиж орууллаа. Цээжилсэн үгээ тэмдэглэх нүд гаргав.

Энэ номоос шинэ үгийн утгыг магадлан олоод, өгүүлбэрийн жишээнээс хэрэглэх аргыг нь ойлгож цээжилснээр, унших чадвартай болж, хоёрдугаар хэлээрээ бодох чадвартай болгох зорилго тавив. Энэ номыг урьдчилан давтахад ашиглавал хичээлээ сайн ойлгож, бас үгээ амархан цээжлэхээс гадна, сайн дурынхантай ярихдаа хэрэглэвэл ойлголтыг улам батжуулна. Бас гэртээ энэ номын жишээний талаар эх орныхоо соёл заншилтай харьцуулан ялгаатай талыг ярилцвал төрөлх хэлээ мартажгүй байхад нь тус болж, санал бодлоо илэрхийлэхэд нь хэрэгтэй. Ингэж чадвал хоёр хэл, хоёр соёлын орчин нөхцөлд байгаа хүүхдүүд алийг нь ч мэдэхгүй бус, харин ч аль аль хэлэндээ сайн болж, олон хэл, соёлын дунд амьдрах чадвартай болно гэж найдаж байна.

Монгол улсын нийслэл Улаанбаатар хотод байдаг Монгол улсын их сургуульд анхлан зааж эхэлсэн Япон хэлний боловсрол энэ жил 40 дэх ойгоо угтаж байна. Тэр үед Бүгд найрамдах Монгол ард улс хэмээх нэртэй социалист улс байсан тул одооных шиг чөлөөтэй бус тусгай хүмүүс л виз авч чаддаг байсан. Тийм цаг үед би Монгол улсын их сургуульд уригдан долоодох япон багшаар тэнд нэг жил ажилласан, тэр маань их аз завшаантай хэрэг билээ. Олон сайхан оюутан, хичээл зүтгэлтэй, идэвх зоригтой багш нартай танилцаж чадсан. Энэ удаа миний монголоор орчуулсан бүх үг, өгүүлбэрийг найруулан засаж өгсөн Наранцэцэг багш бас тэр үед их сургуулийн япон хэлний багш байсан. Энэ хүн надад туслаагүй бол би энэ номыг хийж чадахгүй байх байсан. Миний чадан ядан орчуулсан монгол хэлийг хичээнгүйлэн засаж найруулж өгсөнд чин сэтгэлийн талархал илэрхийлмээр байна.

Бас энэ номыг хэвлэхэд туслалцаа үзүүлсэн ХИГҮЧИ Макико багшид гүн талархал илэрхийлье.

Канагава Мужийн Газар Тариалангийн Технологийн Төв

Канагава Газар Тариалангийн Академи

Мэдээлэл боловсруулах (Data processing) Дэд Эрдэмтэн, Лектор ШИМИЗҮ Микио

Энэ номын хэрэглэх арга.

★ Толь бичиг, бие даан сурах материал болгон хэрэглэхэд.

Үгийн утгыг мэдэхгүй тохиолдолд

- ① Япон хэлний цагаан толгойн дэс дараагаар "толгой үг"-нээс хайх.
- ② Канж, үгсийн аймаг, утгыг нь магадлах. Адил дуудлагатай ч гэсэн канж болон үгсийн аймаг нь өөр бол утгын ялгаатай байна.
- ③ "Япон хэлний "жишээ өгүүлбэр"-ийг уншаад яаж хэрэглэж байгааг нь магадлах.
- ④ "Монгол орчуулга"-ыг уншаад японоор өөрийнхөө ойлгож буй утгатай таарч байгаа эсэхийг магадла.
Хэрэв өөр байвал ямар учраас өөр байгааг нь нягтлах хэрэгтэй.
- ⑤ Утга болон хэрэглэх аргыг нь ойлгосон бол дараа нь япон жишээгээ чанга уншиж үзээрэй.
- ⑥ Японоор бичсэн жишээг далдлаж байгаад монгол орчуулгаас япон хэл рүү орчуулах дасгал хийх.
- ⑦ "Япон хэлний жишээ өгүүлбэр" нь өгүүлбэрийн үндсэн загвар тул түгдрэлгүй хэлдэг болтлоо дахин дахин чанга уншаарай.
- ⑧ Цээжилсэн үгнийхээ тэмдэглэх нүд □-нд нь ☑ тэмдэг тавиарай. Тэгвэл цээжилсэн үгийн чинь тоо нэмэгдэж байгааг харахад урамтай. Энэ номон дээр тэмдэглэн бичиж болно, тэгвэл "япон хэлний өөрий гэсэн үгсийн сан"-тай болно.

★ Сурах бичиг болгон заалгах бол

Багш, сайн дурын багш нараас хүсэх нь.

Багш, сайн дурын багш нарт :Заах аргын тухай ганцхан жишээ доор бичлээ.

(Япон хэлээр үзнэ үү.)

Эмхэтгэсэн жишээ, толгой үгийн тухай

Толгой үг

- ① Дараах хэд хэдэн толийг харьцуулан үзэж толгой үгийг шийдсэн болно.

れいかしんこくごじてん さんせいどう
『例解新国語辞典』(三省堂)

だいじりん さんせいどう めいきょうこくごじてん たいしゅうかん
『大辞林』(三省堂)、『明鏡国語辞典』(大修館)

- ② Япон цагаан толгойн дэс дараагаар 6,018 үг жагсаалаа.

- ③ Товчилсон хэлбэр бүхий үгийг, зайны боломжоос болоод толгой үгийн хэсэгт

хаалтанд оруулж тэмдэглэлээ. Жишээ. アルミニウム→アルミ(ニウム)、デフレーション→デフレ(ーション)

- ④ Байнга хэрэглэдэг (1945), нэмэгдэл (116), байнга хэрэглэдэг шинэ (2010 он 11-р сард нэмэгдсэн 196), хүний нэрэнд ордог (өөр хүснэгтэд байгаа) гэх мэт канжийг" канж тэмдэглэх газар" оруулсан.

- ⑤ Дээрх шалтгаанаар канж тэмдэглэх хэсэгт канжийг нь бичээгүй тохиолдол бий. Гэвч огт канж хэрэглэхгүй гэсэн үг биш, бичих явдал бий. Канжтай ч гэсэн ердийн үед, эсвэл бүр огт, хэрэглэхгүй тохиолдол бас бий. Ийм шалтгаанаар япон хэлний жишээг зориудаар канж бичээгүй нь угаас канж хэрэглэх шаардлагагүй гэсэн санаа юм. Иймээс жишээ өгүүлбэрт канж бичээгүй байвал тэр канжийг цээжлэх хэрэггүй.

Жишээ.	みだご 見出し語	かんじひょうき 漢字表記	にほんごようれいぶん 日本語用例文
	・ ひずみ		…、ひずみ ^で が出る。 "歪" гэдэг канж хэрэглэх тохиолдол бий.
	・ つく	つく	ぜい肉 ^{にく} が ^つ つく。 энэ хоёр жишээнээс ямар үед
	つく	つく	今日は ^{つく} ついている。 канж бичихгүй вэ гэдгийг мэдэж болно.

Бас хэд хэдэн үгсийн аймагт багтдаг ижил нэрийг дайвар үгийн утгаар хэрэглэх тохиолдолд канж бичих хэрэггүй.

Жишээ.	みだご 見出し語	かんじひょうき 漢字表記	にほんごようれいぶん 日本語用例文
	・ わりあい	割合	нэр үг
	わりあい		дайвар үг

・ けっこう 結構 тэмдэг нэр, туслах үйл үг

けっこう дайвар үг

Бас атэжи (утга хамаагүй, шууд дуудлагаар нь бичсэн үг)-г угаасаа канжаар бичдэггүй.

Жишээ. みだご かんじひょうき
見出し語 漢字表記

・ めでたい めでたい гэж бичихгүй

Ингэж бичих журмыг доорх толь бичгүүдээс үзэв.

れいかいしんこくごじてん だい はん さんせいどう
『例解新国語辞典』(第六版)三省堂(2002)

しょうがくしんこくごじてん しょはん みつむらきよういくとしよ
『小学新国語辞典』(初版)光村教育図書(2005)

にほんそつききょうかい ひょうじゅんようじようれいじてん
日本速記協会『標準用字用例辞典』

きょうどうつうしんしゃ きし しゃ
共同通信社『記者ハンドブック』

じじつうしんしゃ さいしんようじようご
時事通信社『最新用字用語ブック』

あさひしんぶんしゃ あさひしんぶん ようご てびき
朝日新聞社『朝日新聞の用語の手引』

よみうりしんぶんしゃ よみうりしんぶんようじようご てびき
読売新聞社『読売新聞用字用語の手引』

まいにちしんぶんしゃ まいにちしんぶんようごしゅう
毎日新聞社『毎日新聞用語集』

にっぽんほうそうきょうかい しんようじようごじてん
日本放送協会『NHK新用字用語辞典』

さんせいどう げんだいこくごひょうきじてん
三省堂『現代国語表記辞典』

こうだんしゃ にほんご ただ ひょうき ようご じてん
講談社『日本語の正しい表記と用語の辞典』

ぶんえいどう せいきにほんごひょうきじてん さんしょう
文英堂『21世紀日本語表記辞典』なども参照。

Үгсийн аймгийн тухайд

① Аль үгийн аймагт орохыг нь дээрх толь бичгээс үзэв.

Ангилал болон товчилсон тэмдэгийг доор бичлээ.

名	нэр үг	代	төлөөний нэр	動	үйл үг
補動	туслах үйл үг	形	и-тэмдэг нэр	形動	да-тэмдэг нэр
副	дайвар үг	接	холбоос үг	感	аялга үг
連	тусгай тодотгол	助	туслах нөхцөл	接尾	дагавар

「かなわない」「しかたがない」「ついて」「つれて」 гэх мэт үгийг үгсийн аймагт оруулсангүй.

- ② Нэр, дайвар, гадаад, дууриал үг зэргийн ард "сүрү" залган,
үйл үг болгодог, тэдгээрийг дараах маягаар хаалтанд нь оруулж тэмдэглэв.

Жишээ.	みだし語 見出し語	かんじひょうき 漢字表記	ひんし 品詞
	・ あくしゅ	握手(する)	名・動
	・ ざらざら	ざらざら(する)	副・動
	・ コピー	コピー(する)	名・動

- ③ Хоёроос илүү аймагт багтдаг ижил нэрийг нэг толгой үг болгон орууллаа.
Үгсийн аймгаараа утга нь өөр болох үгэнд тус тусад жишээ бичив.
Гэвч, бичих зай, бусад шалтгаанаар нэр, үйл үг гэсэн хоёр
өөр аймагт багтах үгэнд заримд нь нэг л жишээ бичсэн тохиолдол бий.

Толгой үгийн монгол орчуулгын тухайд

Хичээлийн холбогдолтой толгой үгийн монгол орчуулгыг жишээнд гарсан
өгүүлбэрийн нөхцөл байдлыг үзэж орчууллаа.

Япон хэлний жишээ өгүүлбэрийн тухайд

Бүх канжинд хираганагаар дуудлагыг нь тэмдэглэж хэрэглээ ихтэй жишээг оруулав.

- ① Амьтан, ургамлын нэрийг байнга хэрэглэдэг канж, хүний нэр тэмдэглэдэг (өөр хүснэгтэд байгаа)
канж бол канжаар, байхгүй бол катаканагаар тэмдэглэв. くま
熊、イルカ
- ② Тоо болон тоотой холбоо бүхий үгийг үндсэнд нь араб тоогоор тэмдэглэсэн.
Харин үгийн нэг хэсэг болж эсвэл нийлмэл үг хэллэгт орсон тоон хэллэгийг канжаар бичсэн.

Жишээ.	みだし語 見出し語	かんじひょうき 漢字表記
	・ みかつき	三日月
	・ いっしょうけんめい	一生懸命
	・ ひとりひとり	一人ひとり